

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Гэр хорооллын тулгамдсан асуудлыг хэлэлцэв

Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудын нэг нь гэр хороолол билээ. Үүнийг шийдэх арга замыг хайх зорилгоор "Улаанбаатар хотын гэр хорооллын байдал" нэртэй олон улсын эрдэм шинжилгээний хурал өчигдөр эхэллээ. ШУТИС, UniNET Eurasia Pacific, Венийн технологийн их сургуультай хамтран зохион байгуулж буй хуралд Австри, Япон, Швейцарь, Германы гээд нийт 25 гадаадын эрдэмтэн, архитекторууд оролцож илтгэл тавилаа. Тэд гэр хорооллынхны амьдралын хэв маяг, газрын менежмент, дэд бүтэц, цэвэр бохир усны шугам гээд бүх л асуудлыг хөндсөн байна. ШУТИС-ийн

Барилгын инженерийн сургуулийн архитектурын салбарын эрхлэгч доктор Д.И.Гончигбат "Гэр хорооллын өнөөгийн байдал хөгжлийн бодлогод өгөх санал" үндсэн илтгэлийг тавьсаны дараа урилгаар оролцож буй гадаадын эрдэмтэд өөрсдийн санал бодлоо хуваалцлаа. Монгол гэр гэдэг манай орны нэгэн онцлог тул соёл, өв уламжлалаа алдалгүй, байгалийг сүйтгэхгүй орчин үеийн нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх саналыг дэвшүүлсэн байна. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал нь өнөөдөр өндөрлөх юм.

Ю.ДЭЛГЭР

Conference: The Current Situation of Ger District in Ulaanbaatar!
08-09 July 2007, Ulaanbaatar